

Монголын эдийн засгийн өнөөгийн байдал, Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны зарим асуудал

Т.Дорж *

Ц.Даваадорж **

Товч агуулга: 1990 оноос хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд Монгол улсад зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бүрэлдэж, дотоодын үйлдвэрлэл нэмэгдэн, нэг хүнд ногдох хэмжээ жил дараалан өсөж, ДНБ-ын 80%-г хувийн хэвшлийнхэн бүрдүүлдэг болсноор Монгол улс нь Дэлхийн банкны бага орлоготой орнуудын жагсаалтаас дундаж орлоготой орнуудын жагсаалтад шилжин орсон юм. 1994 онд Монгол улс нь БНХАУ-тай сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцаа тогтоон, цаашид хоёр орны харилцааг шинэ агуулгаар баяжуулан шинэ шатанд гаргаснаар өнөөдөр стратегийн түншлэлийн харилцааны түвшинд хүрээд байна. Монгол – Хятадын харилцаа 1980- аад оноос өнөөг хүртэл хөгжихдөө хэд хэдэн хөгжлийн үе шатыг дамжсан ба тэдгээр нь хэд хэдэн гэрээ хэлэлцээрээр баталгаажсан билээ. 1990-ээд оны сүүлийн хагасаас Хятад улс нь Монголын худалдаа-эдийн засгийн томоохон түнш болж, 2013 оны байдлаар хоёр орны худалдаа 5.5 тэрбум ам.долларт хүрсэн нь Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 52%-ийг эзлэж байна. Монгол дахь БНХАУ-ын хөрөнгө оруулалт 2013 оны байдлаар 398 сая ам.доллар буюу Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 50 орчим хувийг эзлэх болов. Сүүлийн жилүүдэд Монгол, БНХАУ-ын дээд хэмжээний уулзалтууд удаа дараа болж, хоёр орны эдийн засгийн харилцан үр ашигтай халтын ажиллагаа өргөжиж байгаа нь манай улсын хөгжилд дорвитой түлхэц болох нөхцлийг бүрдүүлж байна. Энэ үйл хэрэгт эрдэмтэн судлаачдын хүчийг ашиглан, ул үндэстэй судалгаа, нотолгоонд тулгуурласан төрийн бодлого хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

* ШУА-ийн дэд ерөнхийлөгч.

** ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын орлогч дарга.

* * *

Монгол Улсын макро эдийн засгийн тойм




1990 оноос эхэлсэн зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих асуудал өнөөг хүртэл Монголын Улсын Төрийн бодлогод тусаж, хэрэгжиж ирлээ. Үүний дүнд 2013 оны байдлаар ДНБ-ний 80 орчим хувийг хувийн хэвшил бүрдүүлдэг болж, эдийн засгийн гол шийдвэрүүд зах зээлийн жамаар гарах нөхцөл бүрдэн, зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бүрэлдэн тогтсон байна.

Сүүлийн 10 жилд 2009 оноос бусад онуудад эдийн засаг өсөлттэй байлаа. Суурин хүн амын тоо 2.1 сая хүн байсан бол 2013 оны эцсээр 2.9 сая хүн болж өссөн байна. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн ам 39 хувиар нэмэгдсэн нь хөдөлмөрийн нийлүүлэлт эрчимтэй нэмэгдэж байгааг харуулж байгаа юм. Гэвч ажилгүйдлийн түвшин 2013 онд 7.9% байгаа нь хөдөлмөрийн нийлүүлэлтийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.

Энэ 20 гаран жилийн ололт бол дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, нэг хүнд ногдох хэмжээ жил бүр өссөн явдал билээ. Сүүлийн 10 жилд ДНБ-ний хэмжээ оны үнээрээ 12 дахин, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4 дахин өссөн байна. ДНБ-ний жилийн өсөлтийн хувь ч нэмэгдэж, дэлхийн хэмжээгээр ихээхэн хурдтай өсөж буй эдийн засагт тооцогдож байгаа юм. 2010-2013 оны жилийн дундаж өсөлт 12 хувь орчимд байгаа нь үүнийг баталж байна (Зураг 1).

ДНБ-ний цэвэр өсөлт, бууралт (хувь)



Эх үүсвэр: ҮСХ-ны Монгол улсын статистикийн эмхтгэл, 1989-2002, 2010, 2013

ОЛОН УЛС СУДЛАЛ

Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 2013 онд оны үнээр 6.0 сая төгрөг, харин 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2.1 сая төгрөг болж, 2010 оныхоос оны үнээр 2 дахин, зэрэгцүүлэх үнээр тооцвол 1.4 дахин өссөн байна. Ингэснээр Монгол улс Дэлхийн банкны бага орлоготой орнуудын жагсаалтаас гарч, дундаж орлоготой орнуудын жагсаалтад орлоо.

ДНБ 2012 онд 12.4 хувийн өсөлттэй байснаа 2013 онд 11.7 хувь болж саарсан нь тодорхой шалтгаантай. Сүүлийн жилүүдэд эдийн өсөлтийг жолоодож байсан нүүрсний экспорт, уул уурхайн хөгжлийн санхүүжилт болох гадаадын шууд хөрөнгө оруулалт багассан нь эдийн засгийн өсөлт удаашрах нөхцөл болсон. Гэхдээ үүнийг нөхөж сангийн болон мөнгөний тэлэх бодлого явуулсан нь удаашралыг сааруулсан юм.

2013 онд аж үйлдвэрийн салбар 20.1% өссөн нь нийт өсөлтийн 5.1 хувийг хангажээ. Санхүү, мөнгөний урамшуулал, дэмжлэг авсан барилгын салбар 66 хувиар өссөн явдал аж үйлдвэрийн салбарын энэхүү өсөлтийг нөхцөлдүүлсэн. Оюу Толгой уурхай 2013 оны 6 сараас эхлэн зэсийн баяжмалаа гаргаж эхэлснээр Монголын уул уурхайн салбарын бүтээгдэхүүн гаргалт 20.7% өссөн байна. Үйлчилгээний салбар 10% өссөн нь нийт эдийн засгийн өсөлтийн 4.3%-ийг хангажээ. Цаг агаарын тааламжтай байдал нь хөдөө аж ахуйн салбар 13.5% өсөж, нийт өсөлтийг 2%-иар нэмэгдүүлэх боломж олгожээ.

Ийнхүү эдийн засгийн өсөлтөд салбаруудын оруулж буй хувь нэмэр харилцан адилгүй байлаа. Гэхдээ монголын эдийн засаг өрөөсгөл бүтэцтэй, нэг салбараас хэт их хамааралтай байдал арилахгүй байна.

ДНБ-ий ашиглалтын бүтэц талаас авч үзвэл дотоодын хэрэглээ 16.3% өсөж, нийт өсөлтийн 13.7%-ийг бий болгожээ. Харин нийт хуримтлал 2.1%-иар өссөн нь эдийн засгийн өсөлтийн 1.5%-ийг эзэлж байна.

Монголын гадаад эдийн засгийн харилцааны өөрчлөлт нь манай орны хөгжил дэвшлийн нэг багана тулгуур болж ирсэн. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад орны зээл, тусламжийн ачаар монголын эдийн засаг өсөж, өргөжих болсон билээ. Монгол улс 1997 онд Дэлхийн

Худалдааны Байгууллагад элсэн орсноор дэлхийн улс орнуудтай тэгш эрхтэй олон талт худалдаа хийх өргөн боломж нээгдэж, улмаар олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд бүрэн эрхтэйгээр оролцох нөхцөл бүрдсэн. 2013 онд 135 оронтой худалдаа хийж, нийт эргэлт 10.6 тэрбум ам.долларт хүрчээ.

Хүснэгт 1. Монгол Улсын 2013 оны гадаад худалдааны эргэлт

| | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|----------------------------|--------|---------|---------|---------|
| Нийт эргэлт, сая ам.доллар | 6108.6 | 11415.9 | 11123.0 | 10626.9 |
| Үүнээс: экспорт | 2908.5 | 4817.5 | 4384.7 | 4269.1 |
| Импорт | 3200.1 | 6598.4 | 6738.4 | 6357.8 |

Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2013
Гадаад худалдааны бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Экспортын бүтэц, %-иар, орноор

| | 1990 | 1995 | 2000 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|------------|------|------|------|------|------|------|------|
| БҮГД | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| ОХУ | 78.3 | 14.5 | 8.4 | 2.8 | 2.0 | 1.8 | 1.4 |
| БНХАУ | 1.7 | 16.4 | 51.9 | 84.8 | 92.2 | 92.6 | 86.8 |
| БНСУ | - | 5.5 | 2.2 | 1.0 | 0.8 | 0.3 | 0.3 |
| АНУ | 0.1 | 5.4 | 24.3 | 0.2 | 0.1 | 0.08 | 0.09 |
| Их Британи | 4.0 | 3.9 | 3.3 | 2.31 | 0.4 | 0.27 | 4.7 |
| Япон | 1.1 | 9.8 | 1.5 | 0.09 | 0.23 | 0.13 | 0.24 |
| Бусад | 14.8 | 44.5 | 8.4 | 8.8 | 4.27 | 4.82 | 6.47 |

Эх сурвалж: ҮСХ. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2013

Хүснэгт 3. Импортын бүтэц, %-иар, орноор

| | 1990 | 1995 | 2000 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| БҮГД | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 | 100 |
| ОХУ | 77.51 | 50.08 | 33.55 | 32.71 | 24.62 | 27.42 | 24.57 |
| БНХАУ | 2.41 | 10.71 | 20.47 | 30.5 | 30.8 | 27.8 | 28.67 |
| БНСУ | 0.09 | 5.17 | 9.05 | 5.68 | 5.40 | 6.94 | 7.98 |
| АНУ | - | 3.49 | 4.62 | 4.96 | 8.12 | 7.95 | 8.06 |

ОЛОН УЛС СУДЛАЛ

| | | | | | | | |
|-------|-------|-------|-------|-------|-------|------|------|
| Япон | 1.06 | 9.8 | 1.5 | 6.14 | 7.43 | 7.44 | 6.99 |
| Бусад | 18.93 | 20.75 | 30.81 | 20.01 | 23.63 | 28.9 | 24.9 |

Эх сурвалж: ҮСХ, Монгол Улсын статистикийн эмхтгэл 2013

2013 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурсан нь тоног төхөөрөмжийн импортыг багасгахад нөлөөлсөн бөгөөд нийт дүнгээр импорт 5.7% буурах шалтгаан болжээ.

Хэрэглээний Үнийн Индекс 2013 онд 10.4% болж, онилж байсан хэмжээнээс давсан. Хэдийгээр үнэ тогтворжуулах арга хэмжээг Монгол банкнаас авч явуулсан боловч үр дүн нь хүссэн хэмжээгээр гарсангүй. Энэ нь мөнгөний нийлүүлэлт ихэссэн, Сангийн болон Мөнгөний тэлэх бодлогоос улбаатай гэж судлаачид үзэж байна. Монголын Хөгжлийн Банк нь төсвийн бус зардлын гол санхүүжүүлэгч байгууллага юм. 2013 оны байдлаар зам, дэд бүтцийн салбарт ДНБ-ий 9.6%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг санхүүжүүлжээ. Санхүүжилтийн эх үүсвэрийн цөм нь Чингис бонд, 2012 онд гаргасан 5 жилийн хугацаатай, 580 сая ам.долларын Евро бонд, 2013 онд гаргасан 290 сая ам.долл-ийн Самурай бонд зэрэг болно.

Улсын өрийн хэмжээ 2010 онд ДНБ-ний 35.9% байсан бол 2012 онд 63.0%, 2013 онд ч энэ хэмжээнд байна. Урсгал тооцооны алдагдал 2013 онд 3.2 тэрбум ам.долларт хүрч ДНБ-ний 27.4%-д хүрчээ. Гэхдээ 2012 онд 32.6%-д хүрч байсныг бодвол эерэг үр дүн гэж үзэж болох нь. Гадаад худалдааны алдагдал 2012 онд ДНБ-ний 22.8%-д хүрч байсан бол 2013 онд 18.1% болж багасах хандлагатай болсон. Гадаад валютын нөөц 2012 онд 2.2 тэрбум ам.доллар байснаа 2013 онд 1.9 тэрбум ам.доллар болж буурснаар 4 сарын импортын хэмжээтэй тэнцэх болов. 2013 оны эхэнтэй харьцуулахад монгол төгрөгийн ханш ам.долларын эсрэг 27%-иар суларсан байна.

Ерөнхийд нь авч үзвэл 2013 онд Монголын эдийн засаг өмнөх онтой харьцуулахад өсөлт саарсан байдалтай байлаа. 2014 оны манай орны эдийн засгийн өсөлт Дэлхийн Банкны тооцоолсноор 6% орчим, харин АХБ-ны тооцоогоор 9.5% орчим байх нь. Иймд эдийн засгийн дорвитой, зөв оновчтой бодлого авч хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Ингэж байж эдийн засгийн өсөлтийн сааралтыг

зогсоож, өндөр өсөлтийг хадгалах учиртай. Гадаад орнуудтай эдийн засгийн харилцаагаа өргөтгөж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, сангийн болон мөнгөний бодлогоо зохистой болгох нь монгол улсын цаашдын эдийн засгийн хөгжлийн зангилаа асуудал болж байна. Энэ бүхний үндэс нь ул суурьтай судалгаа шинжилгээний ажил хийж, эрдэмтэн судлаачдынхаа бүтээлийг бодлогод тусгаж байх явдал болно.

1. Монгол – Хятадын эдийн засгийн харилцааны төлөв байдал

Монгол улс 2 их гүрний дунд оршдог, далайд шууд гарцгүй орон билээ. Энэ утгаараа 2 хөрштэйгөө эдийн засгийн харилцаагаа өргөжүүлж, харилцан ашигтай хамтран ажиллах нь хөгжлийн нэгэн баталгаа болох юм.

1990-ээд оноос өмнө Монголын гол хамтрагч Орос улс байлаа. Хөгжлийн тодорхой шалтгаанаас энэ харилцаа багасаж ирсэн ба харин үүнийг орлон Хятад улстай харилцах нь илүү нэмэгдсэн байна.

1994 онд Монгол улс нь БНХАУ-тай сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцаа тогтоон, цаашид хоёр орны харилцааг шинэ агуулгаар баяжуулан шинэ шатанд гаргаснаар өнөө стратегийн түншлэлийн харилцааны түвшинд хүрээд байна. Монгол – Хятадын харилцаа 1980- аад оноос өнөөг хүртэл хөгжихдөө хэд хэдэн хөгжлийн үе шатыг дамжсан ба тэдгээр нь дараах гэрээ хэлэлцээрээр баталгаажсан. Үүнд: “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ” (1994 он), “Сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа” (2003 он), “Стратегийн түншлэлийн харилцаа байгуулах талаарх хоёр талын Тунхаг бичиг” (2011 он), “БНХАУ, Монгол Улсын хооронд стратегийн харилцааны дунд, урт хугацааны Хөтөлбөр” (2013 он), “Хилийн шугамын хэлэлцээр” (1962, 1984 он) зэрэг болно.

1990-ээд оны сүүлийн хагасаас Хятад улс Монголын худалдаа-эдийн засгийн томоохон түнш болон хувирч, 14 жилийн турш хамгийн том харилцагч хэмээн тооцогдож байна. 2013 оны байдлаар Монгол-Хятадын худалдаа 5.5 тэрбум ам.долларт хүрсэн ба экспорт 3.7 тэрбум, импорт 1.8 тэрбум ам.долларт хүрсэн нь Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 52%, экспортын 86.8%, импортын 28.6%-

ОЛОН УЛС СУДЛАЛ

ийг Хятад улс дангаараа эзэлж, яах аргагүй манай улсын худалдааны том түнш болохыг нотолж байгаа юм.

**Хүснэгт 4. Монгол Улс ба БНХАУ-ын гадаад худалдаа
(тэрбум ам.доллар)**

| | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|-------------|--------|--------|--------|--------|
| Нийт эргэлт | 3442.7 | 6472.8 | 5933.1 | 5528.9 |
| экспорт | 2446.3 | 4439.9 | 4059.7 | 3706.3 |
| импорт | 976.2 | 2032.9 | 1873.5 | 1822.6 |

Эх сурвалж: ҮСХ. Монголын статистикийн эмхтгэл 2013

Зөвхөн гадаад худалдааны салбараар зогсохгүй санхүү, хөрөнгө оруулалтын хувьд ч хамгийн том түнш болсон. Монгол дахь БНХАУ-ын хөрөнгө оруулалт 2013 оны байдлаар 398 сая ам.долларт хүрч, энэ нь Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 50 орчим хувийг эзлэх болов. Монгол Улсад бүртгэлтэй Хятадын хөрөнгө оруулалттай 6000 гаруй компани ажиллаж байна. Зээл тусламж, бага хүүтэй зээлийг ч ихээр олгож байгаа юм. 2014.6.13-нд Хятадын банкны УБ дахь төлөөлөгчийн газар Туушин группт 25 сая ам.долларын зээл олгов. Энэ бол нэг л жишээ. Монголын 40 гаруй компани 3 тэрбум ам.долларын зээл авахаар Хятадын банкны УБ дахь салбарт хандаад байна.

Сүүлийн жилүүдэд Монгол, БНХАУ-ын дээд хэмжээний уулзалтууд удаа дараа болж, 2 орны эдийн засгийн харилцан үр ашигтай хамтын ажиллагаа өргөжиж байна. Энэ оны 8 сарын 21-22-нд БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн нь хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэхэд томоохон түлхэц болно.

Монгол Улс, БНХАУ хоорондын харилцааны түвшинг дээшлүүлж, улс төрийн харилцан итгэлцлийг гүнзгийрүүлж, хоёр талын эдийн засаг, зам тээвэр, дэд бүтэц, санхүү, хилийн боомт, соёл, хүмүүнлэг зэрэг салбарын хамтын ажиллагаанд бодит ахиц гарч өндөр, дээд түвшинд олон чухал асуудлаар тохиролцоонд хүрсэн нь энэ айлчлалын гол үр дүн болов. Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал болон

хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн Засгийн газар, байгууллага хоорондын 26. аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны 11 баримт бичигт гарын үсэг зурсан нь манай улсын хөгжилд дорвитой түлхэц болох нөхцөл бүрдэж байна гэж үзэхээр байгаа юм. Үүнийг харин манай улс хэрхэн ашиглаж, хөгжлийн хурдаа нэмэх вэ гэдэгт анхаарах хэрэгтэй байна.

Хятадын нутгаар дамжин тээвэрлэгдэх Монгол Улсын транзит ачаанд 40 хувиас доошгүй тарифын хөнгөлөлт үзүүлэх, төмөр замын 4 боомт шинээр нээх, далайн гарцтай боомтыг нэмэгдүүлж, Азиас Европ руу чиглэсэн дамжин өнгөрөх ачааны гуравны нэгээс доошгүйг Монголын нутгаар тээвэрлэх талаар ярилцаж, үндсэндээ тохиролцлоо.

Манай улсын хувьд ийм өргөн боломж нээгдсэн бөгөөд цаашид бидний бодлого, үйл ажиллагаанаас хамаарах боллоо. Энэ үйл хэрэгт эрдэмтэн судлаачдын хүчийг ашиглан, ул үндэстэй судалгаа, нотолгоонд тулгуурласан бодлого хэрэгжүүлэх нь амжилттай хэрэгжих нөхцөл болох юм. Энэ хэрэгт Монголын Шинжлэх Ухааны Академийн эрдэмтэн судлаачид оролцоход бэлэн байна